

БАТЛАВ:  
СҮМЫН ЗАСАГ ДАРГАХ Ч.БАТДЭЛГЭР

**ГУРВАНЗАГАЛ СҮМЫН 2019 ОНД ОНХСАНГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР  
ХИЙГДЭХ АЛСЛАГДСАН БЭЛЧЭЭРТ “ГҮН ӨРМИЙН ХУДГИЙН ЦООНOG”  
ГАРГАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

2019.03.25

Сүмийн булаг

Уст цэг, цооног гаргах ажлыг “Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага” MNS6088:2010 стандартын дагуу “Усны мэргэжлийн байгууллага” хийж гүйцэтгэнэ.

№	Үзүүлэлтүүд
<b>1.Цооногийн төсөв, тоо хэмжээ</b>	
1.1	Цагаанхошуу багийн Баруун хар нуур, Хөх чuluуны хоолой гэх газруудын бэлчээрт 2 цооног, Сүмийн булаг багийн төвд 1 цооног, нийт 3 ширхэг гүн өрмийн худгийн цооног гаргана.
1.2	Нийт мөнгөн дүн 21 сая төгрөг /1 цооног 7 сая төгрөг/
<b>2.Цооног өрөмдөх, цооногийг тоноглох</b>	
2.1	Геофизикийн судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтооно.
2.2	Өрөмдмөл худгийн цооногийн ашиглалтын ундарга нэг цагт $2 \text{ m}^3$ -ээс $6 \text{ m}^3$ ус өгөх хүчин чадалтай байна.
2.3	Суултын болон шүүрийн яндангийн материал нь ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндан байна.
2.4	Ус өргөх ган буюу зөвшөөрөгдсөн хуванцар яндангийн диаметр 32 мм байна.
2.5	Цооног дахь суултын яндан, шүүр нь 20-оос доошгүй жил ашиглах нөхцлийг хангасан байвал зохино.
2.6	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 10-15мм байна.
2.7	Худгийн шавхалт хийх хугацаа 24 цаг байна.
2.8	Худгийн уснаас дээж авч шинжилгээ хийлгэсэн байна.
2.9	Худгийг түр хугацааны тагаар тоноглох шаардлагатай.
<b>3. Худгийн насос, цахилгааны утас, хянах самбар</b>	
3.1	Гүний насос: ISO9001 стандартын шаардлага хангасан. Монгол орны уур амьсгалын нөхцөлд ашиглах боломжтой байна. Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байна.
3.2	Цахилгааны утас нь худагт ашиглах шаардлагыг хангасан 3 фазын, насосноос хянах самбар хүртэл үргэлжилсэн (залгаасгүй), ус өргөх янданд 2м тутамд хавчиж тогтооно.
3.3	Хянах самбар нь асаах, унтраах товчлууртай байна. Насос ажиллаагүй байх үед ногоон гэрэл, хүчдэл өгч ажиллаж байх үед улаан гэрэл асаж байхаар тохируулна.
<b>4. Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх</b>	
4.1	Талбайг цэвэрлэнэ. /өрөмдлөгийн шлам, талбай зассан цементний баглаа боодол, хайрга чuluу болон ахуйн хог хаяг гэх мэт/
4.2	Худаг, гүний насос, жижиг оврын генераторыг ажиллуулах, үйлчилгээ хийх талбайн сургалтыг худаг ашиглагч нарт хийнэ.
4.3	Худгийн паспортыг бэлтгэж, баталгаажуулан сумын ЗДТГ-ын Хөдөө аж ахуйн тасагт хүлээлгэж өгнө.

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам” –ыг мөрдөнө.

БОЛОВСРУУЛСАН:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ: Г.ЦЭЦЭГСҮРЭН /ЗДТГАЗРЫН ДАРГА/  
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: А.ШИНЭЦЭЦЭГ /ХАА-Н ТАСГИЙН ДАРГА/  
ГИШҮҮД: П.АЛТАНЖАРГАЛ /ТАТВАРЫН УЛСЫН  
БАЙЦААГЧ/  
С.СҮХБОЛД /УЛСЫН БҮРТГЭГЧ/  
О.БАТБҮРГЭД /МАЛ ЭМНЭЛГИЙН БАЙЦААГЧ/